

паспорттай хүн ч байдаг суралтай юм билээ. „Ардчилалын буянаа ингэж тогтоцгоов. Улсын нэр хүндэд халтай тэдний ийм бизнесийг гэм буруутган гэм зэмгүй л өнгөрч байлаа. Сүүлийн жилүүдэд радиотелевизээр Солонгосын виз, Америкийн, Германы „виз түргэ гаргана“ гээд, түүнд нь хууртсан хичнээн ч хүн хохирч байна. Засаг төр нь ч, иргэд нь ч, ерөөсөө хашраахгүй, тоохгүй явж иржээ.

Мөхөс би гадаад харилцаа, гадаад бодлогын салбарт гарсаа олон ололт амжилтыг бүхэлд нь үгүйсгэх гэсэн юм биш ээ. Зөвхөн засуулштай бөгөөд улс орны аюулгүй байдал, нэр хүндэд хортой зарим нэг үйлдэл, бодчиггүй хэрэг явдлын талаар судлаачийн хувьд уншигч олонтойгоо саналаа хуваалцаж буй нь энэ юм. Үүнтэй холбогдуулан гадаад харилцаа намчирхах, нутгархах явдал, элдэв бүлгийн ашиг сонирхлоос ангид байх ёстой үздэгээ дурьдъя. Нэг сургуулийн орос хэлний багш Гадаад Хэргийн сайд, нэг намын дарга Элчин сайд, ганзагын наймаачид дипломат болж байх юм <<Дипломат, гадаад харилцаа мэргэжил биш>>, хэн дуртай нь хийдэг улс төр гэж үзэж туйлширч болохгүй гэж үзнэ.

Дэлхийн олон орны эрдэмтэд, судлаачид гадаад бодлого дипломат ажиллагааг шинжлэх ухаан хэмээн хүлээн зөвшөөрч, онол үзэл баримтлал боловсруулж мөрдөж ирсэн байна. Олон улсын харилцааны түүх, эрх зүй, улс төр судлал, эдийн засгийн харилцааны салбаруудын эрдэмтэдийн бүтээл туурвилыг тоолоод баршгүй. Бид Англи, АНУ, Франц, Орос, Герман, Япон зэрэг улсын судлаачдаас тоймтой нэрд гарсан бүтээлүүдээс нь суралцах судалж байна. Тэхээр ОУХ, дипломат ажиллагаа мэргэжил, тэхдээ бүр нарийн бөгөөд онол, практикийн хослолд тулгуурласан баймааж үр өгөөжтэй байх мэргэжил мөн.

Эл байдлаас үүдэн Улсын Их Хурал, „Дипломат албаныхууль“ гаргасныг судлаачийн хувьд бүрэн дэмжсэн юм. Гадаад Хэргийн Яам, төр улсын гадаад үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах түүнд хяналт тавих болж буй нь зүйтэй. Харин дээдэс маань хууль дээдэлж түүнийг биелүүлэх ёстой. Турга тусгаар Монгол улсын хөгжил, цаашилбал хувь заяанд гадаад ая таатай нөхцлийг бүрэлдүүлэхэд энэ хууль чухал хувь нэмэр болно хэмээн итгэж явна.

Монгол улсын гадаад харилцааг нэгдмэл, нэгэн зорилготой чиглүүлэн, өнгөрсөн үеэсээ сургамж авсан, олон улсын

харилцааны өнөөгийн хандлага, өнө хэтээ <<даяарчлалын>> энэ катуухан орчинд зохицсон уян хатан прагматик арга ухаанаар хэллэн явуулах нь чухал юм. Тэрхүү <<даяарчлалын>> орчинд Монголын зах зээл, бүтээгдэхүүний талаар өрсөлдөх чадвар бүрэлдэж байна уу? Бидний ярих дуртай болсон монгол хүний аюулгүй байдал, сайн засаглал хангагдаж хэрэгжиж байна уу?

Гадаадын зээл тусламжийг үр өгөөжтэй ашиглаж чадав уу? Гэж нэгэн өдөр төрөөс асууна!

Гадаад бодлого, дипломат ажиллагаа бүхэлдээ Монголын дотоод амьдралыг тохируулахад чиглэсэн, үндэсний эрх ашгийг дээдэлсэн, эх оронч нэгэн үзүүрт сэтгэл өвөртөлсөн баймааж нь турга тусгаар улс маань 21-р зуунд улс үндэстнээ дэлхийн олон үндэстний тоосонд даруулахгүй тэсэж үлдэж <<Монгол гэдэг эрийг ертөнцийн чихнээ>> дуурсгаж явах болно.

ГЕОПОЛИТИК БА УЛСЫН ХҮЧ ЧАДАА, БОДЛОГО

МУИС, ОУХС-ийн багш,
Онц бөгөөд Бүрэн Эрхт
Элчин Х.Олзвов

Геополитик (газарзүйд үндэслэсэн бодлого) бол газарзүй, улсын чадал боломж болон олон улсын бодлого дээр төвлөрсөн ухаан, үйл ажиллагаа юм. 1800-аад оны сүүлээр анх үндэслэгдсэн геополитикийн онол нь 20-р зууны эхээр ихээхэн газар авч байснаа дэлхийн хоёрдугаар дайны үеэр нацист Герман түүнийг амьдрах орон зайгаа („Lebensraum“) тэлэх эрмэлзлээ зөвтгөх онолын үндэслэл болгосноос дэлгэрэлт нь зогсонги болж харгис үзлийн хэлбэр хэмээн шүүмжлэгдсэн билээ. Эхний үеийн болон ид цацгэлалтийн үеийн олонхи геополитикч улс бол „амьд биет“ учраас тэлж өргөжиж байх ёстой агаад эс тэгвээс нөхөх, төлжих, хөгжих нөхцөлгүй болно гэсэн шугамыг барьж байлаа. Далайд ноёрхох, мөн колони эзэмшлийн нутагтай болох нь дэлхийд нөлөө, хүчээрээ ноёрхох үндэс гэсэн Альфред Махэн, Европ, Ази, Африк нь „дэлхийн арал“ бөгөөд түүний төв болсон Евроазийн „зүрхэн газар“ („Heartland“) -т нөлөө хүчээ тогтоовол дэлхийг захирна гэсэн Х.Маккиндер, Европ, Ойрхи Дорнод, Африк, Өмнөд Америк, Азийн

зах хүрээ („Rimland") бол АНУ-ын хувьд Евроазийн гурнуудийг хол байлгах хашлага учраас тус орны аюулгүй байдлыг хангах түлхүүр үндэс гэсэн Николас Спайкмэн нарын онол нь нэгэн үе Англи, Америк, Германы гадаад бодлогын үндэс болж байсан хэдий ч нацистуудын ойлгон хэрэглэсэн геополитик шиг тийм жишмээр санаа бодол төрүүлж байгаагүй юм. Одоо ч үндэс нь байсаар. Евразийг далайн эргээс дотогш хүмин римлэндийг өргөтгөхөд анакандын бодлого ч чиглэж байгаа юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа геополитикийн онол практик бодлогын үндэс болсоор байсны илрэл нь АНУ-ын дипломатч Ж.Кеннаны дэвшүүлсэн тогтоон барих („containment") бодлого билээ. Энэхүү коммунизмын тархалтыг тогтоон барихад чиглэсэн үзэл санаа АНУ, түүний холбоотнуудын гадаад бодлогод 40 гаруй жил зонхилсон түүхтэй. Тогтоон барих бодлого бол н.Спайкмэний римлэндийн онол дээр тулгуурлаж байсан бөгөөд нөлөөний хүрээ („sphere of influence")-ний тухай зэрэг олон үзэл баримтлал ч том гурнуудийн гадаад бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд үндэслэл болж байсныг бас дурдуулштай. Нөлөөний хүрээ гэдэг нь нэг их гүрний эрх ашгийн хүрээлэлд оршиж, түүний ноёрхолд автагдсан газарзүйн бүс нутаг бөгөөд нөгөөтэйгүүр бусад гүрэн хөндлөнгөөс уг бүсэд халдах, орохыг хориглосон зарлаагүй болон албан ёсны хэлэлцээр гэж ч ойлгож болох юм. Энэ утгаараа геополитикийн нэг үндсэн үзэл баримтлал болжээ. Тухайлбал, Монрогийн номлолын дагуу АНУ, Төв болон Өмнөд Америкийг өөрийн нөлөөний хүрээнд оршиж буй гэж үзсээр иржээ.

Дээр хэлснээс үзэхэд, геополитик бол аливаа улсын гадаад бодлогоор илэрхийлэгдэж биелэлээ олж байдаг ажээ. Харин тэр, энэ улсын гадаад бодлого нь геополитикийн илэрхийлэл болохдоо үндэсний хүч бололцоог харуулсан олон хүчин зүйлээс хамаарч өөр өөр шинж төрхтэй байдаг. Тухайлбал, жижиг, сул улсуудын үндэсний хүч нөлөө нь бага учраас тэдний зүгээс олон улсын харилцаанд оролцох, ялангуяа нөлөөлөх боломж тун өчүүхэн байдаг. Ер нь чадал нөлөө буюу чадамж нь „зорилгод хүрэх хэрэгсэл, өөрөө бас зорилго бөгөөд дотоодын болон олон улсын улс төрийн үйл явцын гол хэрэгсэл, үндсэн зорилт юм." гэж Даниель С. Папп тодорхойлжээ.* Нөгөөтэйгүүр, хүч нөлөө бол харьцангуй ойлголт юм. Бүх нөхцөлд аль нэг улс хүч нөлөөгөө ашиглаж чаддаг байсан

бол тэр гүрний дэлхийд туйлын ноёрхол тогтох биз ээ. Тиймээс ч М.С.Горбачев 1990 онд Зөвлөлтийн цэргийн төсвийг багасгах тухай шийдвэр гаргах хүч нөлөөтэй байсан бөгөөд Ж.Буштай уулзах эсэхээ ч тодорхойлж чадаж байв. Гэтэл мөн үед ЗХУ-аас тасран тусгаар тогтнох гэсэн литвичуудийг итгүүлж чадаагүй билээ.

АНУ-ын ерөнхийлөгч зэвсэгт хүчинээ Ирак, Сомалид оруулах тушаал өгч гүйцэтгэсэн ч худалдалдааны хязгаарлалтын практикаас нь ялончуудыг нэг хэсэг татгалзуулж чадаагүй билээ.

Хүч нөлөөний үр дүн ямар нөхцөл байдлад түүнийг ашиглаж буйгаас ч хамаарах нь бий. Хэдий АНУ цэрэг, эдийн засгийн асар их хүч нөлөө бүхий гүрэн боловч Иранд тэдний элч, төлөөлөгчдийг барьцаалан авсантай холбогдсон хямралын үед үндсэндээ яаж ч чадаагүй билээ. Афганистаны ядмалхан зэвсэгтэй партизанууд Зөвлөлтийн цөмийн зэвсэг бүхий хүчит зэвсэгт хүчинтэй тулалдаж алсан зэрэг жишээ олныг татаж болно.

АНУ-ын нэрт профессор Ханс Моргентау хүч нөлөөг түүнийг ашиглаж буй улс, байгууллага, хувь хүн ба тийм хүч нөлөөнд автагдаж буй улс, байгууллага, хувь хүний хоорондын сэтгэл зүйн харилцаа гэж үзсэн байдаг.* Х.Моргентаугийнхаар, хүч нөлөөгөө ашиглах нь хүч нөлөөнд автагчийн шийдвэрт нөлөөлж чадаж буй нь тэрхүү хүчинд автагдагчид ашиг горилсон, хориг цээрлэлээс айсан, эсвэл хүч нөлөө үзүүлэгчийг хүндэтгэснээс болдог ажээ. Энд олон улсын эрхзүйн чухал зарчмууд, түүний дотор улс орнуудын тэгш эрх, харилцан ашигтай байх зэрэг эрх зөрчилдөж хүчтэний өмнө хүчгүй нь буруутай болдог гэсэн үзэл давамгайлж буйг мэдэж чадах юм алга.

Х.Моргентау олон улсын харилцаанд хүч, чадал нөлөөний гүйцэтгэх үүргийг дөрөв хувааж тодорхойлсон байна. Үүнд:

1. Чадал (power) ба нөлөө (influence)-г утгын хувьд ялган үзэж, чадал гэдэг нь үр дүнг тодорхойлох чадвар, нөлөө нь үр дүнг тодорхойлогчдын шийдвэрт нөлөөлөх чадварын утгыг тус тус илэрхийлнэ гэжээ. Жишээ нь, гадаад харилцааны сайд ирэх онд ямар зорилгоор аль оронд дээд хэмжээний айлчлал хийлгэх талаар үндэсний Аюулгүйн Зөвлөлд асуудал оруулж саналаа дэвшүүлэх боловч зөвхөн уг зөвлөл шийдвэр гаргадаг. Энэ нь сайд нөлөө үзүүлэх чадавхтай боловч хэрэв зөвлөл сайдын саналыг хүлээн авбал л түүний нөлөөний үр дүн гарна гэсэн үг. Харин онолын хувьд сайдын санал зөвлөмжгүй ч гэсэн

Үндэсний Аюулгүйн Зөвлөл шийдвэр гаргах чадалтай юм.

2. Х.Моргентау чадал ба хүчийг (force) ялган үзсэн байдаг. Түүний үзлээр, хүч бол бодитойгоор хүчирхийлэл үйлдэх явдал бөгөөд тэгснээрээ хүч нөлөөний (чадлын) сэтгэл зүйн үр дагаварыг устгаж буй юм. Хүчтэй улс нь чадлыг заналхийлэл болгон ашиглахаас биш бодит байдал болдоггүй гэж Х.Моргентау номлосон байдаг. Гэтэл олон улсын харилцаанд хүч хэрэглэсэн, хэрэглэж ч байгаа бодит жишээ олон байгааг хэлбэл зохино.

3. Х.Моргентау ашиглаж болох чадал, үл болох чадал гэж ангилсан байдаг. Цөмийн чадавхи болон түүнээ хэрэглэхээр заналхийлэх нь зарим тохиолдолд үндэсний хүч чадлын итгэлтэй хэсэг боловч өнөөгийн тохиолдолд тийм үнэлэлтэд хүрэхгүй гэж хүчний онолыг баримтлагч үзсэн байна. Гэхдээ Монгол бол далайд гарцгүй (Land-Locked), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (Nuclear-Locked), их гүрнүүдээр хашигдсан (Big Power-Locked) орон гэдгийг бид санах ёстой. Мөн Өмнийн шар аюул (Макиндерийн хэллэг) ч их бий.

4. Х.Моргентау бас ёс суртахууны хүч чадал, хууль ёсны хүч чадал гэж хуваагаад улс төрийн үзэл суртал нь үндэсний үйл ажиллагаагаа хууль ёсны гэж зөвтгөдөг гэж баталдаг. ЭЗХТЗ-ийн жишээ ч үүнийг батлах байх

Товчхон хэлэхэд, хүч чадлын тухай Х.Моргентаугийн дүгнэлт нь олон улсын харилцааны реалполитик буюу хүчээр түрээ барих онолыг зөвтгөж байгаа нь илт юм. Энэ утгаараа хүчээр заналхийлэн буулт хийлгэх, нөлөөнийхөө хүрээнд байлгах, сул дорой улсыг дагуул болгох гэх мэт олон сөрөг уршигтай бөгөөд тиймээс их гүрнүүдийн геополитикийн энэ онол бодол хүчтэй зэвсэг болсоор байна

Улсын хүч чадлын тухай ярихад түүнийг бүрдүүлж буй хэсгүүдийг мэдэх ёстой. Гол бүрэлдэхүүн хэсгийг дор товч авч үзье

Улсын хүн ам бол хүч чадлын чухал хэсэг гэгддэг. Хүн амыг тооны талаас нь, мөн боловсрол мэргэжлийн үүднээс авч үзэх хүч чадлын нэг хэсэгт тооцдог. БНХАУ дэлхийн хамгийн олон хүч амтай орон учир их гүрэн гэхийн хамт хүн амын боловсролыг төвшин нь бусад гүрний хэмжээнээс доогуур гэдгийг бас харгалзаж чадавхийг нь бууруулан тооцдог. Хятад ч шинэчлэлийн жилүүдэд хүн амын боловсрол, шинжлэх ухаан, техникийн мэдлэгийг дээшлүүлэх талаар асар их анхаарч байгаа билээ. Шинэчлэл

нээлтэй бодлогын онолоо хэрэгжүүлж эхлэхдээ Дэн Сяопин юуны өмнө Өрнөдийн орнууд руу олон залуусыг сургуульд илгээсэн нь учиртай. Улсын хүн ам түүний хүч чадлыг нэмэгдүүлэх, зэвэл бууруулахад гүйцэтгэж буй үүрэг бас зохион байгуулалт, удирдан чиглүүлэлт, аж үйлдвэрийн сууриас хамааралтай байдаг. Манай улсын хувьд гэвэл хүн ам цөөн, харин боловсролын төвшин харьцангуй өндөр боловч хүн амын аж байдал, улсын санхүүгийн баршсгал, сургалтын төвшин бүхэлдээ сайжраагүй нь сөрөг нөлөө үзүүлсээр байгаа билээ.

Улсын хүч чадлын чухал хэсэг болсон хүн амын байдалд зарим шинжилгээ хийж зэрэг, сөрөг талыг товчхон харуулж жишээ болгоё. Улс хичнээн хүн амтай, нас, хүйсний харьцаа, эрүүл мэнд болон боловсролын байдал, тэр бүүхэл сэтгэл санааны байдлыг ч судалдаг.

Олон хүн ам нь цэрэг эрс бэлтгэх, үйлдвэрийг ажиллагсдаар хангах зэрэг хэд хэдэн сайн талтай боловч тэр нь улс орны баялаг тийгээд санхүү, орон сууцны боломж, улирлын байдал гэх мэтэй харьцуулахад сөрөг үр дагавартай байх тохиолдол олон. Энэтхэг 1 тэрбум 27 сая гаруй хүн амтай боловч нэг хүнд оногдох ҮНБ нь 270 ам.доллараас илүүгүй тул тэднийг хоол хүнсээр хангахад ихээхэн хүч, нөөц баялгаа зарцуулах шаардлагатай байдаг.

Балтадеш гэхэд нутаг дэвсгэр бага боловч 123 сая хүн ам нь 2.9 саяар жилд өсч байна. АНУ-ын нэг иргэнд жилд 6000 ам.доллар зарцуулж байхад энд дөнгөж 30 доллар гаргадаг. * Мөн гадагш гарах бололцоог ч нэмдэг. Урд талын гүрний бодлого ч үүнийг гэрчлэх биз.

Улс орон бүтээлч насны хүн ам олонтой бол чухал баялаг гэдэг. Ийм бүлгийнхэнд 15-65 насны хүмүүсийг оруулж тооцдог ажээ.

Зарим орны хүн ам хурдан өсч байвч тэжээх тэтгэх насны хүүхдүүдийн хүн амд эзлэх хувь өндөр байдаг нь сайн үзүүлэлт биш. Зарим оронд олонхи иргэд нь бүтээлч насаа дуусгалгүй эхрээг орхиж, заримд нь өндөр настны тоо асар их байна. Дэлхийн хүн амын 32 хувь нь 15 насанд хүрээгүй хүүхэд, 6.5 хувь нь 65, түүнээс дээш насны хөгшчүүл багтана. Манайд ч бодох юм гарсан. Манави улсад 15 наснаас дооших хүүхдийн хүн амд оногдох хувь 32-ийн багта, Хойд Солонгост 15-64 насныхан олон, Норвегид өндөр настны тоо их гэсэн тооцоо бий. * Хүн амын тэг өсөлттэй алтга мэтний орон алсдаа ажиллах хүчний дутагдалд орж, өндөр алсдаа их хөрөнгө зарах байдалд орж мэдэх юм. Манавид хүүхдэд

зарцуулах хөрөнгө оруулалт асар их байгаа нь санхүү, эдийн засгийн бэрхшээлд оруулж байна.

Хүн ам эрүүл чийрэг, боловсролын төвшин өндөр байх нь зэрэг үзүүлэлт билээ. Бас хүн амын сэтгэл санааны байдал сайн, засгийн газар болон удирдагчдаа итгэлтэй байх нь улс орны хүч чадлыг зузаатгах хүчин зүйл гэдэг нь тодорхой.

[Газарзүй улсын хүч чадлыг тодорхойлоход бас чухал үүрэгтэй. Чухам эндээс улс төрийн бодлогыг газарзүйн байр сууринаас тодорхойлдог геополитикийн ухаан гарсан билээ. Б.Наполеон: „Аль нэг улсын бодлого газар зүйдээ оршино“ гэж хэлсэн байдаг нь сонин бөгөөд бодох зүйл.

Ер нь геополитикт газарзүйн хүчин зүйл чухал. Ойрын хүчтэй улсын нөлөө зэрэг буюу сөрөг талаар нөгөө улсын хөгжил, уналт, босолтод тусдаг. Оросын нэрт геополитикч П.Н.Савицкий „Татарчилалгүйгээр Орос орон байхгүйсэн“ гэж бичиж байлаа. Үнэндээ Монголын эцэг өвгөд Орост их нөлөөлсөн, том гүрний бодлогын учир холбогдлыг заасан, эсвэл ухааруулсан гэж бодном. Өнөөдөр Еврази П.Савицкий, Н.С.Трубецкой гэх мэтийн үеэс өөр болж, Орос задарч олон тусгаар туургатай улс бий болсон ч байж болох юм. АНУ, Япон, БНСУ ч манайхыг дөрөөлөн тийшээ лавшрах бодлоготой ч байж болох. Энэ бүхнийг бид нэгтгэн дүгнэх хэрэгтэй, геополитикийн үүднээс бодох ёстой болсон болов уу.

Том нутаг дэвсгэр улсын хүч чадлыг зузаатган, бусад хүчин зүйлийн хамт аюулгүй байдлыг нь хангахад чухлаар нөлөөлснийг дэлхийн хоёрдугаар дайнд ЗХУ ялсан буюу аврагдсан жишээнээс харж болно. Оросын газарзүйн байрлал буюу асар их хүйтэн, том бүсэд оршдог нь тус улсад довтолсон гурван улсын арми ялагдахад их нөлөөлсөн гэж судлаачид үздэг. АНУ нь Атлантын болон Номхон далай хэмээх хоёр их халхавч бүс („buffer zones“-тэй учир халдлагад өртөлгүй өдий болжээ.

Газар нутгийн хэмжээ, байршил тэр бүр давуу тал бодлогтуй тал бий. Хүн ам цөөтэй бөгөөд зэвсэгт хүчин нь аль ч талаараа шалгуур даахгүй бөгөөд далайд гарцгүй, хоёр их гүрнээр хүрээлэгдсэн, том нутаг дэвсгэртэй байдал Монгол улсын гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй аюулгүй байдлын хувьд санаа амар байхын аргагүй гэдгийг бид мэднэ. Орос ч гэсэн жилийн турш хөлддөггүй ганц ч

боомтгүй нь гадаад худалдаа, далайн тээврийн ачаа бараа тээвэрлэх боломжийг нь хязгаарласан хүчин зүйл болжээ.

Оросын өргөн уудам нутаг дэвсгэр нь Номхон далай, Хар тэнгис, Хойт мөсөн далай зэрэг газарт бие даасан далайн цэргийн болон худалдааны флоттой байхыг зайлшгүй шаарддаг. Ширэнгэ их ой, өндөр уул, даваа, цөл говь хүртэл цэрэг дайны ач холбогдолтой. Манайх шиг цөөн цэрэг, хүн ам багатай орны урт хилийг бүрэн найдвартай хамгаалах асуудал нэн бэрхшээлтэйг бид ойлгодог билээ.

Байгалийн баялаг улсын хүч чадлын чухал бүрдэл хэсэг мөн. Байгалийн баялгийн эзэмшил, ашиглалт, хяналт, хэрэглээ гэсэн дөрвөн төвшингөөр баялгийн ач холбогдлыг тодорхойлдог. Байгалийн их нөөц, баялаг геополитикийн давуу тал боловч түүнээ эзэмшиж хянаж байх чадвар өндөр биш бол давуу талын тэмжээндээ хүрэхгүй нь мэдээж. Хүн ам цөөтэйгөөс гадаадын хөлсний ажилчид хязгаар, хяналтгүй авах ч үндэсний хүч чадал, аюулгүй байдлыг сулруулах талтай. Улсын геополитикт үүнийг тэгэхээр нэн анхаарах ёстой. Гэхдээ хамтын ажиллагааг хариуцлагатай боловсруулсан гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр хөгжүүлэх нь зайлшгүй бөгөөд ашигтай хувилбар мөнөөсөө мөн. Газрын тос экспортлогч орнуудын байгууллага (ОPEC)-ын гишүүд энэ чухал, стратегийн ач холбогдолтой баялагтаа хяналтаа тогтоож бодлогоо зохицуулж эхэлмэгц тэдний олон улсын байр суурь хүчтэй болж, газрын тосыг их гүрнүүдийн тулгалт, шахалтын зэрэг зэвсэг болгож болох нь батлагдсан билээ.

Байгалийн баялгаа өөрийн улсын үйлдвэр, эдийн засгийн хөгжлийн тусын тулд хэрэглэж байгаа нөхцөлд л баялагтайн ач холбогдол бүрэн мэдэгдэнэ. Зэсийн болон төмрийн баяжмал, кохших нүүрс зэргээрээ БНХАУ-ын хойд муж, ӨМӨЗО-ыг хангах, тэр хэмжээгээр далайд гарцтай болох эрхээ уялдуулан бэхжүүлэх стратегийн бодлого баримтлах асуудлыг ч бид авч үзмээр санагддаг. Үүнээс гадна хятадын ажиллах хүчинээс хий айх, өндөр үнэ хөөх асуудалтай ч хамтатган авч үзүүлштэй мэт бодогддог. Гэхдээ „Хятадын шар аюул“-ыг байна гэж бодох хэрэгтэй.

Аж үйлдвэрийн чадавхи улсын хүч чадлыг зузаатгах бас нэг гол хүчин зүйл юм. Үндэсний аж үйлдвэр хөгжсөн орнууд дайны цагт ялагчаар тодордог нь XIX, XX зууны дайн, байлдааны түүхээс тодорхой харагддаг. Гэхдээ жижиг хэмжээний дайны үед үйлдвэр-

лэлийн өндөр хөгжил бас тийм их үр дүнтэйгээр улсын хүч чадлыг нэмэгдүүлж чаддаггүй гэж зарим судлаачид үздэг бөгөөд Франц, хуучин ЗХУ, АНУ өөрөөсөө хүч чадлаар сул Алжири, Афганистан, Вьетнамын үйлдвэржээгүй, улсын чанартай бүс хүчинтэй тэмцэхдээ асар их бэрхшээлтэй тулгарсныг жишээ болгон иш татдаг. Энд хүн амын эх оронч үзэл, эв нэгдэл, олон улсын эв санааны дэмжлэг илүү их үүрэгтэй байсан. Энхийн цагт бол аж үйлдвэржилт нь улсын эдийн засгийн хүч чадлыг нэмж хүн ардын амьдралын нөхцлийг дээшлүүлж, засгийн газрын дэмжлэгийг өргөжүүлдэг.

Үйлдвэржилтийн талаар ярихдаа Япон зэрэг орныг жишээ болгон хүч чадал нь нэмэгдэж байгаа ч гадны түүхий эд, эрчим хүчнээс нэн хамааралтай болсныг нь эрдэмтэд тэмдэглэн дурддаг нь бас л гүн утгатай.

Цэргийн хүч нь улсын хүч чадлыг харуулдаг учир геополитик боловсруулахад чухалчлан авч үздэг. Зарим судлагч цэргийн хүчийг улсын жинхэнэ бодит хүч чадлын ганц илэрхийлэл гэж батлахыг оролддог. Гэхдээ энэ бол хэтрүүлсэн үнэлэлт юм. Плануриа тайван цагт цэргийн хүчийг ингэж үнэлж болохгүй. Японы үндсэн хууль зэвсэгт хүчний хувьд хягаарлалт тавьсан учир энэ улсын цэргийн хүч харьцангуй их биш, харин эдийн засгийн хувьд нэн их хүч чадалтай гүрэн билээ. Цэргийн хүчний тоо, чанарыг янз бүрээр хэмждэг бол энгийн болон цөмийн зэвсгийн ашиг тус ч ялгаатай. Цэргийн хүчийг гадаадад ашиглах талаас, эсвэл эх орноо хамгаалах зорилтын үүднээс авч үзвэл чадварыг нь өөр өөрөөр тооцох ёстой. Цэргийн төсөв зардал, сургалт дэдлэгийн чанар, нөөц бүрэлдэхүүний байдал, техникийн хангамж гэх мэт олон асуудал цэргийн хүчийг судлан дүгнэхэд заавал анхаарагддаг ажээ.

Нэг чухал асуудал бол цэргийн хүчээ ашиглах хүсэл эрмэлзэлтэй эсэхэд хамаарна. Вьетнамын дайны үед Өмнөд Вьетнамыг тусгаар тогтносон хэвээр аль болох урт хугацаанд хадгалахыг америкийн элит хэсэг хүсч байсан ч ард түмний дийлэнх олонхи нь эсрэг саналтай байв. Эцсийн эцэст ард түмний санал дийлсэн бөгөөд 1975 онд БНСВУ Өмнөд Вьетнамыг буулган авахад ард түмэн ч, элит ч эргэн очихыг хүсэхгүй байв.

Удирдах бүрэлдэхүүн ард түмний хүсэл эрмэлзэл, бодол санааг зүгшрүүлэн зөв удирдахад голлох үүрэг гүйцэтгэдгээс гадна улсын чадамж, бололцоог хэрхэн ашиглахад их нөлөөлдөг ажээ.

АЛТАН АРГАМЖ

Энэ бүхэнд удирдах бүрэлдэхүүний геополитикийн мэдлэг, олон улсын байдлыг дүгнэх чадвар, гадаад харилцааны байгууллага, дипломатч нарын дүн шинжилгээ хийх үр чадварын төвшин туйлын чухал билээ.

АНУ-ын ерөнхийлөгч агсан Р.Никсон, үндэсний аюулгүй байдлын зөвлөх асан Х.Киссинжер нарын геополитикийн үр чадвар, мэдлэг нь ЗХУ, БНХАУ-ын зөрчлийг ашиглах, ЗХУ-тай яриа хэлэлцээгээ таслалгүйгээр БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоох, Тайванийг тайвшруулах замаар Хятадын бодлогоо эргэлт хийх талаар түүхэн үүрэг гүйцэтгэх бололцоог АНУ-д олгосон билээ. Энэ нь зүй ёсоор дэлхийн дипломатын түүхэнд төрийн дипломат бодлогын урлагийн жишээ болон тэмдэглэгдсэн гэж үзэж байна. Үнэхээр ч Х.Киссинжерийн тэмдэглэсэнчилэн, "...стра-тегийн зохиомж хийхдээ алсыг харж чаддаг Никсон Америкийг ноёрхолчийн байр сууринаас удирдагчийн хэмжээнд хүрэх замаар жолоодож чадсан." билээ. * Х.Киссинжер ерөнхийлөгч Ричард Никсоны геополитикийн мэдлэг, авьяасыг үнэлэн бичихдээ дорхи зүйлийг онцолсон байдаг.

Тухайлбал:

"Америкийн өөр ямар ч ерөнхийлөгч олон улсын асуудлын тухай тийм агуу их мэдлэггүй байлаа."

"Өөрийн нь анхаарлыг татсан аль ч орны улс төрийн хөдөлгөгч хүчийг ойлгон мэдрэх лут их чадвар түүнд байв. Мөн геополитикийн бодит байдлыг түүний ойлгох нь үнэхээр гайхамшигтай байсан юм... Гэвч гадаад бодлогын асуудал гарахад түүний дүн шинжилгээ хийх хүчит үр чадвар, геополитикийн онцгой зөн совин нь Америкийн ашиг сонирхол дээр үргэлж илтээр төвлөрдөг байлаа."

"Никсон бол Теодор Рузвельтээс хойш анх удаа Америкийн гадаад бодлогыг үндэсний ашиг сонирхлын үүднээс явуулсан ерөнхийлөгч юм."

Дээрхээс үзвэл, төрийн удирдагчийн нэг үлгэр дуурайлт шинж тэмдэг илэрхий байна. Сургамжтай сануулга юм! Засаг, төрийн тогтвортой байдал, намчирхах биш, үндэстнээ гэх байр сууринаас аливаад хандаж эв нэгдлийн эрх ашгийг чухалчлах үзэл, удирдах бүрэлдэхүүний нэр хүнд, үлгэрлэн өөртөө татах чадвар зэрэг нь зайлшгүй тооцогдох хүчин зүйлүүд юм.

Нэг тэмдэглэх зүйл бол алдарт Монголч эрдэмтэн О.Латимор гуай геополитик, түүний учир холбогдлыг ойлгодог, тэгэхдээ ихээхэн өөр бодолтой хүн байлаа. „Энэ дэлхий хагас ардчилсан, хагас нь колончилогдсон, хагас нь хараат, хагас нь чөлөөт байвал удаан тэсэхгүй... Бидний асуудал бол энэ асуудлыг яаж хянах биш, харин бид үүнд өөрсдийгөө яаж зохицуулах вэ” гэж бичиж байлаа. АНУ-ын тэр үеийн бодлогын учрыг л хэлсэн байх л даа.

Дэлхий өнөөдөр ардчилал, зах зээлийн замаар эргэлт буцалтгүй ороод байна. Энэ нь хүч чадлыг хамтын ажиллагааг өргөтгөх, хүн төрөлхтний өмнө тулгарсан шинэ зорилтуудыг хамтран шийдвэрлэх өргөн бололцоо нээгдээд байна.

Өнөөгийн хорвоочлолын нөхцөлд даян дэлхий, агаарын болон сансар мандлыг ч хамарсан энэ үйл явцад үндэсний онцлогоо хадгалан үндэсний хэмжээгээрээ оролцох, бүсчилэл, интеграцчилалд хамаарагдах нь улсын хүч чадлыг нэмж, бие даасан байдал, тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэх нэмэлт бололцоог олгох юм.

Харин шашин, үндэстэн ястны асуудлыг ард түмний эв нэгдэл, эрх ашгийн үүднээс зөв зохицуулж байх нь хорвоочлолын үеийн нэг чухал шаардлага юм. Улсын чадал, хүчийг нэмэгдүүлэхэд дээрх зүйлүүд нэн ач холбогдолтой.

Хорвоочлол нь мэдээллийн, цахим хэрэгслийн, биотехникийн хувьсгалын үеийг авч ирлээ. Улс бүр, хүн бүр үүнийг түргэн тусгаж, бодитойгоор үнэлэн үйл ажиллагаандаа тодорхой анхаарах цаг аль хэдий нь болчихоод байгаа билээ.

Зохиогчийн үзэж байгаагаар улс орны хүч чадлыг тодорхойлох өөр хүчин зүйлүүд ч байна. Ийм хүчин зүйлд улс орны эдийн засагт эзэлж буй гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтэц (их гүрнүүдийн ашиг сонирхлыг бүрдүүлэх нь аюулгүй байдлын нэг баталгаа ч гэж үзэж болно)-ийн байдал, тухайн орон, бүсийн болон олон улсын эдийн засгийн интеграцид орсон эсэх, оролцооны чанар, төвшин, улс орны улс төр, эдийн засгийн системийн хэлбэр (ардчилал, зах зээлд шилжиж буй эсэх, хурдац, бэрхшээл, гадаадын дэмжлэгийн төвшин) зэргийг бас оруулан тооцох ёстой. „Уравдахь хөрш” гэж үнэхээр байгаа бол энэ чухал хүчин зүйл. Харин ийм оронд аль улсыг ямар шалгуураар оруулах, Монголын аюулгүй байдалд занал учрах ахул тэр хөрш ямар алхам хийх,

Тийм нөхцөл байгаа эсэхийг Монгол улсаа цөмийн зэвсэгт Ассамблейн чуулганы тогт сэтгэл санааны томоохон чадлыг бэхжүүлж байг санагдана. Гэхдээ энэ бо удирдагчид нь ч, бусад бичигч би сананам.

300 жилийн өмнө

Энэ бол баталгаа ша

зуун бол цахим иргэний

байна гэж их эрдэмтэн Л.Тү

хөдлөшгүй үнэн. Ийм үед мэдлэг

ажээ. Одоо эдийн засгийн хүч чадал гэх

илүүд үзэх зуун гараад байна. Оюуны их ча

ард түмэн ч хэт их гүрний дайтай байж болох нөхцөл

аль хэдий нь нээгджээ. Геополитикийн үндсэн зарчмуудыг ч

засах, хорвоочлогын үе буюу орон зай, цаг хугацаа, хил хязгаар

даван туулаад буй өнөө үед улсуудын геополитикийн чадамжийг

үнэлэх цоо шинэ шалгуур бий болгох, тэр үндсэн дээр улсын гадаад

бодлого, чиг баримжааг шинэчлэх цаг ирлээ.

Ашигласан зарим эх сурвалж:

1. Daniel S. Papp. Contemporary International Relations, Fourth Edition, 1994, p. 393
2. Hans Morgenthau. Politics Among Nations: The Struggle for Power and Peace, N.Y., Knopf, 1973, p. 28
3. John T. Rourke. International Politics on the World Stage, Fifth Edition, 1995, p. 252, p. 253
4. Henry Kissinger. Diplomacy, N.Y., 1994, p. 704
5. Strategic Atlas. A Comparative Geopolitics of the World Powers, Third Edition, Gerald Chailand and Jean-Pierre Ragel, 1983, p. 1
6. Geoffrey Parker. Western Geopolitical Thought in the Twentieth Century, 1985, p. 112 (O. Latimore, The Inland Crossroads of Asia)

Нэг тэмдэглэх зүйл бол алдарт Монголч эрдэмтэн О.Латимор гуай геополитик, түүний учир холбогдлыг ойлгодог, тэгэхдээ ихээхэн өөр бодолтой хүн байлаа. „Энэ дэлхий хагас ардчилсан, хагас нь колоничлогдсон, хагас нь хараат, хагас нь чөлөөт байвал удаан тэсэхгүй... Бидний асуудал бол энэ асуудлыг яаж хянах биш, харин бид үүнд өөрсдийгөө яаж зохицуулах вэ? гэж бичиж байлаа”. АНУ-ын тэр үеийн бодлогын учрыг л хэлсэн байх л даа.

Дэлхий өнөөдөр ардчилал, зах зээлийн замаар эргэлт буцалтгүй ороод байна. Энэ нь хүч чадлыг хамтын ажиллагааг өргөтгөх, хүн төрөлхтний өмнө тулгарсан шинэ зорилтуудыг хамтран шийдвэрлэх өргөн бололцоо нээгдээд байна.

Өнөөгийн хорвоочлолын нөхцөлд даян дэлхий, агаарын болон сансар мандлыг ч хамарсан энэ үйл явцад үндэсний онцлогоо хадгалан үндэсний хэмжээгээрээ оролцох, бүсчилэл, интеграцчилалд хамаарагдах нь улсын хүч чадлыг нэмж, бие даасан байдал, тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэх нэмэлт бололцоог олгох юм.

Харин шашин, үндэстэн ястны асуудлыг ард түмний эв нэгдэл, эрх ашгийн үүднээс зөв зохицуулж байх нь хорвоочлолын үеийн нэг чухал шаардлага юм. Улсын чадал, хүчийг нэмэгдүүлэхэд дээрх зүйлүүд нэн ач холбогдолтой.

Хорвоочлол нь мэдээллийн, цахим хэрэгслийн, биотехникийн хувьсгалын үеийг авч ирлээ. Улс бүр, хүн бүр үүнийг түргэн тусгаж, бодитойгоор үнэлэн үйл ажиллагаандаа тодорхой анхаарах цаг аль хэдий нь болчихоод байгаа билээ.

Зохиогчийн үзэж байгаагаар улс орны хүч чадлыг тодорхойлох өөр хүчин зүйлүүд ч байна. Ийм хүчин зүйлд улс орны эдийн засагт эзэлж буй гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтэц (их түрнүүдийн ашиг сонирхлыг бүрдүүлэх нь аюулгүй байдлын нэг баталгаа ч гэж үзэж болно)-ийн байдал, тухайн орон, бүсийн болон олон улсын эдийн засгийн интеграцид орсон эсэх, оролцооны чанар, төвшин, улс орны улс төр, эдийн засгийн системийн хэлбэр (ардчилал, зах зээлд шилжиж буй эсэх, хурдац, бэрхшээл, гадаадын дэмжлэгийн төвшин) зэргийг бас оруулан тооцох ёстой. „Гуравдахь хөрш” гэж үнэхээр байгаа бол энэ ч чухал хүчин зүйл. Харин ийм оронд аль улсыг ямар шалгуураар оруулах, Монголын аюулгүй байдалд занал учрах ахул тэр хөрш ямар алхам хийх,

тийм нөхцөл байгаа эсэхийг гүнзгий судлан тогтоох ёстой. Мөн Монгол улсаа цөмийн зэвсэггүй бүс гэж зарласныг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы тогтоолоор бүх гишүүн орон дэмжсэн нь сэтгэл санааны томоохон дэмжлэг болж манай үндэсний хүч чадлыг бэхжүүлж байгааг тэмдэглэхгүй өнгөрч болмооргүй санагдана. Гэхдээ энэ бол тунхаглал юм шиг. Ер нь геополитикийг удирдагчид нь ч, бусад нь ч ойлгомсоор, бодмоор гэж өчүүхэн бичигч би сананам.

300 жилийн өмнө Ф.Бэкон мэдлэг бол хүч гэж хэлсэн билээ. Энэ бол баталгаа шаардахгүй үнэн хэвээр өдий хүрэв. Харин XXI зуун бол цахим иргэншлийн зуун, био-иргэншлийн зуун болох нь байна гэж их эрдэмтэн Л.Түдэв доктор саяхан хэлсэн нь бас л хөдлөшгүй үнэн. Ийм үед мэдлэг бол хүч, хурд, хөрөнгө болдог ажээ. Одоо эдийн засгийн хүч чадал гэхээсээ оюуны хүч чадлыг илүүд үзэх зуун гараад байна. Оюуны их чадавхитай жижигхэн ард түмэн ч хэт их түрний дайттай байж болох нөхцөл бололцоо аль хэдий нь нээгджээ. Геополитикийн үндсэн зарчмуудыг ч сэлбэж засах, хорвоочлолын үе буюу орон зай, цаг хугацаа, хил хязгаарыг даван туулаад буй өнөө үед улсуудын геополитикийн чадамжийг үнэлэх цоо шинэ шалгуур бий болгох, тэр үндсэн дээр улсын гадаад бодлого, чиг баримжааг шинэчлэх цаг ирлээ.

Ашигласан зарим эх сурвалж:

1. Daniel S. Papp. Contemporary International Relations, Fourth Edition, 1994, p.393
2. Hans Morgenthau. Politics Among Nations: The Struggle for Power and Peace, N.Y., Knopf, 1973, p.28
3. John T. Rourke. International Politics on the World Stage, Fifth Edition, 1995, p.252, p.253
4. Henry Kissenger. Diplomacy, N.Y., 1994, p.704
5. Strategic Atlas. A Comparative Geopolitics of the World Powers, Third Edition, Gerald Challand and Jean-Pierre Rague, 1983, p.1
6. Geoffrey Parker. Western Geopolitical Thought in the Twentieth Century, 1985, p.112 (O.Lattimore, The Inland Crossroads of Asia)